



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 23/06

Арвайхээр сум

┌ Бэлтгэх модны тоо хэмжээ тогтоох тухай ┐

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалт, 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэг, "Ойгоос 2024 онд бэлтгэх модны дээд хязгаар батлах тухай" Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2023 оны А/456 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэрээс 2024 онд ойгоос бэлтгэх модны тоо хэмжээ, ойн арчилгаа, цэвэрлэгээний огтлолт, ойн цэвэрлэгээ хийх талбайн хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Аж ахуйн нэгж, нөхөрлөл, иргэдэд ахуйн зориулалтаар бэлтгэх модны хэмжээг тогтоосон хэмжээнд багтаан багуудад бэлтгэх модны хуваарь батлах, ойгоос мод бэлтгэх талбай тусгаарлах, эрхийн бичиг олгох ажлыг зохион байгуулж ажиллахыг ой бүхий сумдын Засаг дарга, Сум дундын Ойн анги (Д.Очирхуяг) нарт даалгасугай.

3.Ойгоос бэлтгэсэн хэрэглээний болон түлээний модыг Нийслэл, Төв аймгаас тээвэрлэж борлуулах бусад аймаг, сум руу зөвшөөрөл олгох, Засаг даргын Тамгын газрыг шаардлагатай эрхийн бичгээр хангаж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж мэргэжлийн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Баясгалан), Бат-Өлзий сумын Засаг дарга (С.Амгалан) нарт үүрэг болгосугай.

4.Төв суурин газруудын айл, өрхийн хэрэгцээт түлээний модыг төвлөрсөн журмаар Бат-Өлзий сумын нутаг дэвсгэрээс 2024 онд бэлтгэх модны хуваарьт багтаан бэлтгэж нийлүүлэх, тус аймагт үйл ажиллагаа явуулж буй ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөлүүдэд Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын зөвшөөрөгдсөн бүсээс мод бэлтгүүлэх хуваарь баталж, ойгоос мод түлээ бэлтгэж ашигласны төлбөрийн орлогыг сумын төсөвт төвлөрүүлэхийг Бат-Өлзий сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (Ц.Чинбаяр), Сум дундын Ойн анги (Д.Очирхуяг), Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын Хамгаалалтын захиргаа (Ц.Банди)-нд тус тус даалгасугай

ДАРГА

О.ПҮРЭВДОРЖ

ХАМГААЛАХ
ТАСВИР
2023.11.29

622301157



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 11 дүгээр сарын 2-ний өдрийн
89/08 дугаар тогтоолын хавсралт

Өвөрхангай аймагт 2024 онд ойгоос бэлтгэх модны хэмжээ

	Сумын нэр	Модны төрөл	Ойгоос мод бэлтгэх тоо хэмжээ (шоо.метр)			Ойгоос мод бэлтгэх нийт талбайн хэмжээ (га)	Үүнээс			
			Хэрэглээ	Түлээ	Бүгд		Цэвэрлэгээний отлолт	Арчилгааны отлолт	Уламжлалт бүтээгдэхүүн үйлдвэрлэх	Ой цэвэрлэгээний ажлаар
1	Бат-Өлзий	Шинэс	6000	15300	21300	265	44	30	20	171
	Нийт									
	Үүнээс: Орхоны хөндийн байгалийн цогцолборт газраас бэлтгэх мод	3600	3600	-	3600	120	40			80
2	Зүүнбаян-Улаан	2500	200	2300	2500	10	2		-	8
3	Уянга	2500	200	2300	2500	10	2		-	8
4	Хужирт	2900	400	2500	2900	10	2		-	8
5	Хархорин	800	200	600	800	5	-		-	5
	Дүн	30000	7000	23000	30000	300	50	30	20	200

-----oOo-----